

## ХЯТАДЫН ТӨРИЙН ЗАЛГАМЖЛАЛ ДАХЬ ХӨГЖЛИЙН ХӨТӨЧ

Олхонуд Дашдоржийн Баярхүү  
хятад судлаач, профессор

***Товч агуулга:** Өнөөг хүртэл гадаадын судлаач ажиглагчдын толгойг эргүүлж, мэтгэлцүүлж ирсэн нэг маргаантай асуудал болох БНХАУ дахь засгийн эрхийн төлөө тэмцлийн товч түүхийг энэхүү итгэлд дүрслэхийг хичээв. Энэ түүх Хятадын улс төрийн амьдралд гүн шарх үлдээсэн, гашиун сургамжтай боловч өнөөг хүртэл, хойшдоо ч ил далд өрнөх магадлалтай. Нөгөө талаасаа коммунист намаар удирдуулсан, авторитари тоталитари дэглэмтэй энэ улсад төрийн дээд эрх барих ба шийдвэр гаргах механизм хэрхэн өрнөдөг, түүнд ХКН, Хятадын төр хэрхэн ямар үүрэгтэй оролцдогийг энэхүү илтгэлийн хоёр дахь хэсэгт өгүүлэхийг зорьсон болно.*

***Түлхүүр үг:** Зургаа дахь үеийн удирдагчаа тодруулаагүй Хятад*

2018 оны хавар чуулсан БХАТИХ-ын XIII сонгуулийн анхдугаар чуулган олонхийн саналаар Үндсэн хуульд засвар оруулах төслийг баталсан билээ. Энэ нь Хятадын улс төрийн тогтолцоо цаг үетэйгээ зэрэг урагшилж буйг нотлон харуулсан хэрэг хэмээн хятадууд өөрсдөө үздэг. Бусад улс орны улс төрийн тогтолцоотой харьцуулбал Хятадын улс төрийн тогтолцоо өөрийн гэсэн өвөрмөц давуу талтай хэмээн тэд тайлбарладаг. Яг одоо Хятад улсын эрчтэй хөгжил, ялангуяа эдийн засгийн талаарх асар их ололт амжилт нь маш олон улс оронд зээлдэн суралцууштай арга туршлага болсон байж болох мэт.

Хятад улс реформ, нээлттэй бодлого хэрэгжүүлсэн 40 жилдээ асар их амжилтад хүрсэн ба эдүгээ ядуу хүн ам, хот хөдөөгийн хөгжлийн зөрүү, байгаль орчны бохирдол зэрэг олон зүйлийн олон сорилттой тулгарч буй. Гэвч цаашид өөрчлөлтийн эрчээ өсгөж, хөгжлийнхөө явцад элдэв бэрхшээлээ зохицуулж бүрэн чадна, үүний тулд Үндсэн хуульд өөрчлөлт оруулж, удирдлагын асуудлыг шийдвэрлэлээ хэмээн Бээжингийн суртал нэвтрүүлэг ярьж тэмдэглэж байна.

Өмнөх намын их хурлууд, БХАТИХ-ын чуулгануудын үеэр төд дэх үеийн удирдагчдаа тийм албан тушаалд дэвшүүлээ хэмээн нэрлэж сурталчилж, тухайлбал одоогийн Ши Жиньпин даргыг 5 дахь үеийн удирдагч гэдэг байсан бол өнгөрсөн ХКН-ын XIX их хурал, саяхны ардын их хурлын чуулган дээр таг чиг өнгөрсөн нь анхаарал татна.

Хөгжил хурдсах тусам нэг хүний засаглалаар хөгжлөө баталгаажуулья

гэх санаа нэвт мэдрэгдэнэ. Ши дарга залгамжлагч, залгамжлал, 6 дахь үеийн удирдагчийн талаар ил ярихгүй байгаа нь өөрийнх нь дэвшүүлсэн Хятадын онцлог бүхий социализмын шинэ эрин- “Хятад мөрөөдөл”-тэй нь холбоотой гэх тайлбар ч хангалттай явж байна.

Гэхдээ залгамжлагчийг ил зарлаж болдоггүй коммунист Хятадын улс төрийн “хар түүх” түүнд санаа сургамж өгсөн байхыг үгүйсгэмгүй. ХКН ба БНХАУ-ын түүх бол тэр чигтээ улс төрийн дотоод тэмцлийн түүх, эрх мэдлийн төлөө фракцлан тэмцсэнээ цээрлүүлдэг түүх юм. Тэр түүхээс сөхье.

### **Нэг. Коммунист замын мурий сарий - “Соёлын их хувьсгал”**

1950-иад онд Мао Зэдун “Гурван улаан тугийн лоозон” гэгчээ дэвшүүлж, зүүний нугалаа гаргаж байх үест Хятадын дарга Лю Шаоцийн нэр түгэж, Маогийн залгамжлагч хэмээн зарлагдах дөхөж байснаа “Соёлын их хувьсгал”-аар түүнийг хэлмэгдүүлж, шоронд үхүүлсэн эхний хар түүх буй. Дараагийн хар түүх тэр чигээрээ “Соёлын их хувьсгал”-аар үргэлжилнэ. Хувьсгал нэртэй энэ самуун гурван үе шаттай.

1. Эхнийх нь 1966-1969 оныг хамарна. Хувьсгалын шуурга Хятад орныг нөмөрч, нугалаа завхрал доозоо хэтрүүлж, ХКН, Хятадын төрийг бүрмөсөн хөмрүүлсэн ба 1969 онд ХКН-ын IX их хурал хуралдаж, “Соёлын их хувьсгал”-ыг бүрэн сайшааж, пролетарийн диктатурын дор хувьсгалыг үргэлжлүүлэх шийдвэр гаргасан, намын Дүрэмдээ залгамжлалыг хуульчилж, Батлан хамгаалахын сайд Линь Бяо бол Мао даргын залгамжлагч гэсэн заалт оруулжээ.
2. Хувьсгалын II үе 1969-1973 оныг хамарна. Нөгөө залгамжлагч Линь Бяо маань хувьсгалын эсэргүү болж, түүний хувьсгалын эсэргүү бүлгийг бут цохив. Линь Бяо эхнэр хүү, ойрын хамсаатнуудын хамт онгоц хулгайлан СССР рүү зугтав. Тэд замдаа манай Хэнтий аймагт сүйрч амь үрэгджээ. Мао албан ёсны залгамжлагчгүй болж, харин Ерөнхий сайд Жоу Энълай эгзэгийг тааруулан Дэн Сяопинийг цагаатган дэвшүүлжээ. ХКН-ын X их хурал Линь Бяог илчлэн буруушаасан ч пролетарийн диктатурын дор хувьсгалыг үргэлжлүүлэх, дэлхийн дайнд бэлтгэх намын жанжин чиг шугам хэвээрээ гэжээ.
3. Хувьсгалын III үе 1973-1976 онд өрнөжээ. Маогийн гэргий Зян Цин тэргүүтэй “Дөрвөн дээрэмчин” засгийн эрхэнд бэхжлээ. Линь Бяо ба Күнзийг шүүмжлэх кампани өрнүүллээ. Жоу Энълай, Дэн Сяопин нар руу жадны үзүүр чиглэлээ. 1976 оны хавар Дэн Сяопинийг хөөж буулгалаа. Тэр онд Хятадын гурван дээд удирдагч Жоу Энълай, Жү Дэ, Мао нар тэнгэрт халилаа. Залгамжлагч тодорлоо. Тэр нь Хуа Гофэн гэгч НАХЯ-ны сайд гэнэ. Су Жу гэсэн нэртэй байснаа Хуа Гофэн буюу “Хятад улсын толгой” гэсэн шинэ нэртэй болж, бүх эрх мэдлийг гартаа авчээ. Хуад Мао “Чи хэрэг

эрхэлбэл би санаа амар” хэмээн хэлж захисан гэх суртал нэвтрүүлэг түглээ. Зураг хөрөг, аман түүх, дуу шүлэг, жүжиг кино ч “Чи хэрэг эрхэлбэл би санаа амар”-аар дүүрлээ. Мао нас бараад нэг сар болсны дараа “Дөрвөн дээрэмчин”-ийг бут цохиж, баривчлан, улс төрийн тайзнаас үүрд хөөлөө. Энэ гавьяа Хуа Гофэн, Төрийн түр тэргүүн Е Зяньин, Ерөнхий сайдын орлогч Ли Сяньян нарт ногдоно.

Маогийн үхлээр Маогийн эрин үе дуусав уу гэтэл үгүй байлаа. Маогийн тахин шүтлэг бол Хятад орны хувьд түүхэнд нь тохиолдсон хамгийн том гамшгийн нэг юм. Гэвч энэ хэцүү жилүүдэд хүчирхэг Хятад гүрний үндсийг тавьж чаджээ. Тэр нь цөмийн зэвсэг бүхий, хараат бус, НҮБ-д хууль ёсны суудлаа эзэлсэн, хэний ч нөлөөнд автахгүй, бие даасан хүчирхэг Хятад босч иржээ.

### **Хоёр. Маог залгамжлагчдын нэгэн түүх**

“Соёлын их хувьсгал”-ыг 1977 онд ХКН-ын XI их хурал албан ёсоор дуусгалаа. Шинэ эрин үе эхэллээ. Гэм нь Маогийн залгамжлагч гэх Хуа Гофэн зүүний алдаатай бодлогоо үргэлжлүүлэв. Энэ зүүнтнийг саармагжуулахаар намын их хурал Дэн Сяопинийг бүрэн цагаатгаад зогссонгүй, нам-төрийн дээд эрх мэдэл рүү гаргаж иржээ. Тэрээр ХКН-ын 11 дэх сонгуулийн Төв Хорооны алдарт III бүгд хурал гэгчийг 1978 оны 12 дугаар сард хуралдуулан (2018 онд 40 жилийнх нь ой тохиосон) хүндийн төвийг улс төрөөс эдийн засаг руу шилжүүлжээ. Зүүний нугалаа завхралыг эгнэгт алга болгожээ. Үй түмэн зүтгэлтнийг цагаатгаж эргүүлж ажилд оруулсны дотор Хуа Гофэнийг мөргөж унагах хувьтай Ху Яобан, Жао Зыян нар байлаа. ХКН-ын Төв Хорооны дарга Хуа Гофэний дэргэд Төв Хорооны ЕНБД Ху Яобан шийдвэр гаргаад эхэлжээ. Тэгснээ Ерөнхий сайдынх нь албан тушаалыг нь 1980 онд Жао Зыян шилжүүлжээ. 1981 он гэхэд намын дээд тушаалаа Ху Яобанд алдлаа. 1982 онд ХКН-ын XII их хурал зүүнтнүүд ба “Соёлын хувьсгал”-аар дэвшигсдийг улс төрөөс эгнэгт үлдэн хөөж явууллаа.

Залгамжлалын асуудал дахин босч ирлээ. Хятадад яг нэгдүгээр хүн биш боловч хөшигний ард нэгдүгээр хүн болсон, Хятадын реформын эцэг Дэн Сяопин залгамжлагчаараа Ху Яобан, Жао Зыян нарыг зэрэг нэрлэдэг боллоо. Би баруун зүүн талдаа хоёр тулгуур баганатай хүн, тэр хоёр бол эд байна гэж ирээд л нөгөө хоёроо хөөрөгдөж байв.

Өмнө нь Маогийн залгамжлагч гэгдэж байсан Линь Бяо юу болсон, өөрөө Хуа Гофэнийг юу болгож тавьснаа мэдэхийн цаагуур мэддэг хэрнээ хоёрын хоёр залгамжлагчаа ил зарласан нь гайхал төрүүлж байлаа.

ХКН 1981 онд 60 жилийнхээ ойгоор Төв Хорооныхоо VI бүгд хурлыг хуралдуулж, намын үзэл суртлын удирдамж гаргаж, алдаа оноондоо дүгнэлт хийж, Мао даргадаа тодорхойлолт өглөө. “БНХАУ байгуулагдсанаас хойших ХКН-ын түүхийн зарим асуудлаарх шийдвэр” гэх баримт бичигт Маог аугаа их марксист, аугаа их пролетарийн хувьсгалч, стратегич, онолч хэмээн тодорхойлоод түүний

гавьяа нь алдаанаасаа хамаагүй илүү гэж дүгнэжээ. Ойролцоогоор гавьяа нь 70 хувь, алдаа нь 30 хувь юм гэв.

Залгамжлал 1980-аад оны дунд үеийг өнгөртөл хал балгүй явагджээ. Хятадын улс төрийн тэнгэрт мандсан хоёр од нэг нь намаа, нөгөө нь Засгийн газраа удирдан өөрчлөлт, шинэчлэл, реформыг гялалзтал хийж, авилгалын эсрэг томхон тэмцэл өрнүүллээ. Гэтэл нэрлэсэн нэг залгамжлагч нь замын хагасаас зайллаа. 1986 оны 12 дугаар сараас эхлэн Хятад даяар өрнөсөн оюутны жагсаал намыг сүрхий доргиулж, Ху Яобаныг албан тушаалдаа тэсч чадахгүйд хүргэжээ. Хөрөнгөтний либерализмын эсрэг, “Оюуны бохирдол”-той тэмцэх кампанит ажлыг саатуулсан, айж хулчийсан хэрэгт Ху Яобан унаж, Намын Төв Хорооны Улс төрийн Товчооны өргөтгөсөн хурал дээр нам даруулжээ.

Ху Яобанаасаа салсан Дэн Сяопин нөгөө тулгуур баганаа түлхээд гаргаад иржээ. Ерөнхий сайд Жао Зыянд ХКН-ын Төв Хорооны ЕНБД-ын албыг хавсруулан өгчээ. Тэрээр улс төрийн өндөрлөгт хоёр жил суув. Залгамжлагчаар хоёр жил ажиллав. Ерөнхий сайдын албаа Ли Пэнд өгч, өөрөө намын XIII их хурлаар албан тушаалаа баталгаажууллаа. Дэн Сяопин тэтгэвэр рүүгээ явж байгаа аятай намын дээд сонгуульт бүх албанаасаа татгалзаж, харин цэргийн дээд хоёр албаа (ХКН-ын Төв Хорооны Цэргийн зөвлөл, БНХАУ-ын Цэргийн төв зөвлөл) залгуулж үлдлээ.

### **Гурав. Таван үеэ нэрлэдэг практик**

Итгэл хүлээлгэсэн нөгөө нэг тулгуур багана маань даан ч удсангүй зэсээ цухуйлгалаа. 1989 оны хавар Бээжин хотын төвд оюутан залуус босч тэмцэн хуурай өлсгөлөн зарлаж, ардчилал эрх чөлөө шаардан, улмаар үймээн самуун дэгдээж цэрэг оруулж цус урсган даржээ. ХКН-ын 13 дахь сонгуулийн Төв Хорооны IV бүгд хурлыг зарлан хуралдуулж Жао Зыяныг бүх албан тушаалаас хөөж гэрийн хорионд хийж шийтгэв. “Намын эсрэг, социализмын эсрэг эмх замбараагүй явдлын үеэр нөхөр Жао Зыяны гаргасан алдааны тухай” илтгэлийг Ерөнхий сайд Ли Пэн тавьж хэлэлцүүлэв. Жао Зыяны оронд хэн ч төсөөлөөгүй, хаа хамаагүй Зян Зэминь гэгчийг Шанхай хотын нам-захиргааны дарга байхад нь татаж авчран намын толгойд Дэн Сяопин тавилаа.

Залгамжлал, залгамжлагчийг зарладаг хятадын төрийн уламжлал энэ хүрээд зогсоно. Миний дараа тэр алба авна, тэр намайг залгамжилна хэмээн Зян Зэминь, Ху Жинтао, Ши Жиньпин нарын хэн нь ч зарлаагүй явсаар өнөө хүрчээ.

Харин Хятадын шинэ түүхийн албан ёсны түүх бичлэгт БНХАУ-ын улс төрийн удирдагчдын 5 үеийг нэрлэж албажуулжээ.

Хятадын улс төрийн залгамжлал:

1. Нэгдүгээр үеийн удирдагчид: Хятадын ардын хувьсгалыг удирдсан Мао Зэдун, Жоу Энълай, Лю Шаоци, Жү Дэ нар
2. Хоёр дахь үеийн удирдагчид: Дэн Сяопин, Чэнь Юнь, Е Зяньин, Ли Сяньянь нар

3. Гурав дахь үеийн удирдагчид: Зян Зэминь, Ли Пэн, Цяо Ши, Жу Рунжи нар
4. Дөрөв дэх үеийн удирдагчид: Ху Жинтао, Вэнь Зябао, У Банго нар
5. Тав дахь үеийн удирдагчид: Ши Жиньпин, Улсын дэд дарга Ван Чишан, БХАТИХ-ын Байнгын хорооны дарга Ли Жяньшү, Ерөнхий сайд Ли Көцян, Хятадын Ардын Улс төрийн зөвлөлдөх зөвлөлийн Бүх Хятадын хорооны дарга Ван Ян нар гэжээ.

Ши Жиньпин өөрийнхөө өмнөх 4 үеэ үнэлэн хэлсэн мэргэн үгс буй:

1. Мао Зэдунээр төлөөлүүлсэн Хятадын коммунистууд БНХАУ-ыг байгуулж, социализмын үндсэн тогтолцоог бий болгосон
2. Дэн Сяопинээр төлөөлүүлсэн Хятадын коммунистууд Хятадын онцлогтой социализмыг бий болгосон
3. Зян Зэминиэр төлөөлүүлсэн Хятадын коммунистууд Хятадын онцлогтой социализмыг ХХI зуунд оруулж хөгжүүлсэн
4. Ху Жинтаогоор төлөөлүүлсэн Хятадын коммунистууд шинэ эринд Хятадын онцлогтой социализмыг хөгжүүлсэн. ХКН-ын XVIII хурлаас хойш Хятадын онцлогтой социализм нь шинэ түүхэн эрин үедээ орж, ард түмэн нь хүртээмжтэй, жаргалтай, амар тайван амьдрах боллоо гэжээ

### **Дөрөв. Дараагийн үе нь хэн юм бол?**

Энд анхаарал татах нь Ши Жиньпиний дараах 6 дахь үеийн удирдагчдын талаар өнөөг хүртэл таг чиг байна. Ху Чунхуа гэх нэг эрхмийн нэр дуулддаг. Тэрээр ХКН-ын Төв Хорооны Улс төрийн Товчооны гишүүн, Гуандун мужийн намын хорооны дарга байж байгаад 2018 оноос Ерөнхий сайдын орлогч болжээ. 1963 онд төрсөн, насны хувьд яалт ч үгүй залгамж халаа гэж хардах үндэстэй. Туулсан зам нь яруу бөгөөд баялаг. Хятадын Комсомол, Түвд, Хэбэй муж, Өвөр Монголд ажиллаж байгаад Хятадын хамгийн хүчирхэг мужийг сүүлийн хэдэн жил удирдлаа. Гуандун мужийн ДНБ гэхэд л Оросынхоос хэд дахин давж байна. Энэ мужийг Хятадын эдийн засгийн локомотив гэж нэрлэдэг ба өмнө нь энэ мужаас Ван Ян дэвшиж, төвд очиж Ерөнхий сайдын орлогч болж байжээ. Ван Ян бол “Нэг бүс-Нэг зам” гэх лут төслийн үзэл санааны анхдагч, Ши даргын баруун гар гэгддэг. Энэ мужаас Жао Зыян, Си Жүнсүнь (Си Жиньпиний аав), Ли Чаньчунь, Жан Дөзян зэрэг нэрт улс төрчид ажлын гараа, улс төрд өгсөх замаа засч байжээ.

Яг одоо БНХАУ-ын Засгийн газарт хяналтын ба эдийн засгийн чиглэлийнхэн давамгайлж байна. Ши даргын зөвлөх, Улс төрийн Товчооны гишүүн Лю Хэ 2018 онд Ерөнхий сайдын орлогч болсныг тухайн үедээ ихээхэн шуугиж хүлээн авч байсан. Хятадын эдийн засгийн дэвшилтэт, идэвхтэй загвар эрэлхийлэгч, олон улсын маш олон асуудал дээр ажиллаж байсан, англи хэлийг сайн эзэмшсэн, америкийн эдийн засгийн сайн мэдлэгтэй, Давосын эдийн засгийн форумд оролцсон гээд түүн дээр дагалдах тайлбар олон. Хятадын Ардын Банкны дарга И Ган дээр акцент их өгч байсан. Санхүүгийн салбарт аядуу бодлого явуулагч,

санхүүгийн тогтвортой байдлыг хангагч, Хятадын мөнгөний бодлогыг олон жил хөтлөлцсөн, олон улсын томхон банкны холбоодтой хэлхээ холбоо сайтай, тэр утгаар Лю Хэ, И Ган нар Хятадын эдийн засгийг хөтлөн явуулах болно, ДНБ-тай харьцах дотоодын их өрийг (260 хувьд хүрсэн) цэгцлэхээр тэр хоёр ажиллана гэж таамаглацгааж байв.

2018 оноос улс төрийн тэнгэрт 4-5 чухал нөхөр шат ахисны дотор Гадаад хэргийн сайд Ван И зүй ёсоор орно. Тэрээр сайдаа хийхийн сацуу Төрийн Зөвлөлийн гишүүн (нэг үгээр Шадар сайд) болсноор Хятадын бодлогод нөлөө бүхий фигур болж байна. Хятадын ГХЯ-ны үүрэг ч өсөөд явчихна. Энд би Ху Чунхуа, Лю Хэ, И Ган, Ван И нараар 6 дахь үеийн удирдагчдын нэрс гаргах гээгүй гэдгээ хүлцье.

Бас нэг онцлог үйл явдлыг нэрлэх хэрэгтэй. ХКН-ын өмнөх хоёр их хурлаас намын дээд байгууллагыг сонгоход Зян Зэминь, Ли Пэн, Жу Рунжи нар төрийн төрийн дээд тушаалдаа үлдэж, харин намын удирдлагаас хасагдан хэдэн сарыг өнгөрөөж, дараа жилийн хавар нь БХАТИХ-ын чуулган хүргэж байж улс төрөөс бүрмөсөн явсан, Ху Жинтао, Вэнь Зябао, У Банго нар мөн тэгсэн, 2017-2018 онд БХАТИХ-ын Байнгын Хорооны дарга Жан Дөзян мөн тэгсэн. Өөрөөр хэлбэл Хятадын Төрийн тэргүүн, парламентын дарга, Ерөнхий сайд нар нь намынхаа дээд сонгуульт албан тушаалгүй хэдэн сарыг үдэж байсан байх юм.

### **Тав. Хөгжлийн хөтөч онол**

Эдүгээ Хятадын хөгжлийн үзэл санааны хөтөч онол-баримтлал нь нэг нэг удирдагчийн нэртэй салшгүй холбоотой. Маркс, Лениний онол болон Мао Зэдунгийн үзэл санаа, Дэн Сяопиний онол, гурвыг төлөөлөх үзэл (Зян Зэминь), шинжлэх ухаанч хөгжлийн үзэл (Ху Жинтао), Хятадын онцлогтой социализмын шинэ эрин үеийн тухай Ши Жиньпиний үзэл санаа гэжээ. Орчин үеийн Хятадын түүх гурван аугаа их удирдагчийг төрүүлсэн: Шинэ Хятадыг байгуулж, тусгаар тогтноулж, хөл дээр нь босгож бие даалгасан Мао Зэдун, шинэчлийн салхи хагалж реформоор Хятадыг хөгжүүлсэн Дэн Сяопин, Шинэ эрин үед Хятадыг удирдаж яваа Ши Жиньпин хэмээн Хятадад үздэг болжээ. Төрийн засаглал, хөгжил дэвшлийн хөтөч онол нь энэ гурван удирдагчийн сэтгэлгээний тусгал байх ажээ.

2018 онд чуулсан XIII сонгуулийн БХАТИХ-ын чуулганы тоо баримтаас эргэж эшлэе. Өмнөх XII сонгуулиас хойших 5 жилд 68 сая хүн ядуурлаасаа салсан (2012 онд 99 сая ядуу хүн байсныг 2017 оны эцэс гэхэд 30 саяд хүргэсэн), Хятадын эдийн засгийн хүчин чадал шинэ шатанд гарсан, дотоодын нийт бүтээгдэхүүн 54 их наяд юаниас 82.7 их наяд юаньд хүрч, дэлхийн эдийн засгийн өсөлтөд үзүүлсэн хувь нэмэр нь 30 гаруй хувьд хүрсэн. Хурдны төмөр зам, цахим худалдаа, хөдөлгөөнт холбооны төлбөр тооцоо зэрэг үзүүлэлтээр дэлхийд тэргүүлээ, хурдны төмөр зам 9000 км байсныг 25 мянга гаруй км-т хүргэлээ, дэлхийн нийт хурдны төмөр замын гурваны хоёр хувийг Хятадынх эзэллээ. Экологи, байгаль орчин аажмаар сэргэж, том том хотуудын агаарын бохирдлыг 50 хувиар багасгаж

чадлаа гэх мэт.

Ядуурлыг эдийн засгийн гол үзүүлэлт болгож байгаа нь хөгжил дэвшлийн уг үндэс нь хүн юм, хүний аж байдал сайжирч байж улс орон өөдөлнө гэдэг Хятадын эдийн засгийн реформын бодлогын гол баримтлал ажээ. Хүнийг хөгжүүлж, хүн өөрөө баяжиж хөлжиж, гэгээрч, эрүүлжиж тэр стандартаараа дэлхийд өрсөлдөх тухай яриа юм. Хэрэв анги бүлгээр авч яривал нийгмийн дундаж давхарга нь бараг 100 хувь болох тухай бүдүүвч юм.

2012 онд ХКН-ын XVIII их хурлаас тун лут зорилт дэвшүүлсэн. Юу гэвэл 2021 онд ХКН байгуулагдсан 100 жилийн ойгоор чинээлэг нийгмийг бүх талаар байгуулна, 2049 онд БНХАУ байгуулагдсаны 100 жилийн ойгоор социалист орчин үеийн орон болж шат ахина гэжээ. 2049 он гэдэг нь Хятад улсын нэг дэх 100 жил дуусч байгаа нь тэр. Хоёр дахь 100 жил эхлэхэд л дэлхийд тэргүүлэх улс болчихсон байх холын стратеги юм.

Харин 2017 онд хуралдсан ХКН-ын XIX их хурал эл хоёр зааг хугацааг “Хос зуу” хэмээн нэрлээд ойрын 100 гаран жилийн төлөвийг тодорхойлохыг зорьжээ. Ирээдүйд социалист орчин үеийн тэр улсыг хэрхэн бүтээн байгуулах вэ? 100 жилээр хөгжлөө төлөвлөх хятадын онолыг задлан үзье.

### **Зургаа. Онолын задаргаа**

Дараах төсөөлөл буухаар 2017 онд намын их хурлын илтгэлд оржээ. Үүнд 2020 оноос энэ зууны дунд үе хүртэл хоёр шаттайгаар хөгжинө. *Нэгдүгээр шатанд* 2020-2035 оны эхний 15 жилд чинээлэг нийгмийг бүх талаар бүтээн байгуулсны үндсэн дээр социалист орчин үеийн болох бүтээн байгуулалтаа үндсэнд нь биелүүлэх. *Хоёр дахь шатыг* 2035 оноос дахин 15 жил зарцуулж энэ зууны дунд үе хүртэл гэж тооцоод тэр үед орчин үеийн бүтээн байгуулалтаа дуусгасны үндсэн дээр Хятад нь цэцэглэн хөгжсөн, хүчирхэг, ардчилсан, соёлч боловсон, эвсэг зохицонгуй, үзэсгэлэнт сайхан орон болгон бүтээн байгуулах болно. Англиар *prosperous, strong, democratic, culturally advanced, harmonious and beautiful* гэснийг буулгаж байгаа нь энэ юм.

XXI зууны эцэс гэхэд Хятад улсын биелүүлэх зорилтод шинэ томьёолол нэмэгдэж орлоо. Тухайлбал өмнө нь дэвшүүлж байсан “Баян, хүчирхэг, ардчилсан, соёлч боловсон, эвсэг зохицонгуй, социалист орчин үеийн орон байгуулна” гэснийг 2050 оноос цааш “Баян, хүчирхэг, ардчилсан, соёлч боловсон, эвсэг зохицонгуй, үзэсгэлэнт сайхан, орчин үеийн, хүчирхэг орон байгуулна” хэмээн өөрчилсөн байна. Өөрөөр хэлбэл XXI зууны хоёрдугаар хагасаас өмнөд хөрш маань “социалист улс” хэмээн нэрлэгдэхгүй болохоор төсөөлөл бууж байна.

“Муур хар байна уу, цагаан байна уу хамаагүй, гол нь хулгана барьдаг байх хэрэгтэй” гэсэн Дэн Сяопиний томьёоллоор Хятадад нийгмийн ямар байгуулал байх нь гол биш, хүмүүсийг идэх хоолтой, өмсөх хувцастай, орох оронтой байлгах нь чухал гэдэг асуудлыг энэ 2021 он гэхэд (ердөө хагас жилийн дараа) бүрэн шийдчихсэн байх ба Хятадад хамгийн либераль шинэчлэл явуулснаар нийгмийн

бухимдал, тэсрэлтийг намжааж, сүйрлээс сэрэмжилж, ард түмнээ хөлжүүлж, гэгээрүүлж, нийгмээрээ чинээлэг дундаж анги болж чадсан бол тэр социалист гэх тодотгол чухал биш л дээ.

Үзэсгэлэнт, хүчирхэг гэдэг хоёр зорилт нэмж шинээр дэвшүүлсэн нь Хятадад экологийн соёлыг чухалчилж, бүтээн байгуулалтын зорилтоо гүнзгийрүүлж, шинэ шатанд ахиулах гэж байгааг илэрхийлсэн хэрэг юм. “Цэлмэг тэнгэр цэнгэг агаартай өдөр олшруулах” кампанит ажил шувтан өрнүүлэхээр төсөөлөл бууж байна.

Агаарын бохирдлын зарим нэг статистик– байгалийн салхиар агаар цэвэршсэн өдөр 30 хувь, хүний хүчээр цэвэршүүлсэн өдөр 70 хувийг эзэлж байна. Нийт 338 хотын агаар мандлын чанарын стандарт хангасан хэмжээ 3/1 хувьд ч хүрэхгүй байна. Тэгэхлээр бохирдол ноцтой хэмжээнд байсаар байна гэсэн үг. Агаарынхаа бохирдлоор Хятад нь дэлхийд толгой цохиж яваа бол түүнийг ариусгаснаараа бас толгой цохино гэсэн лут зорилт дэвшүүллээ. Агаараа хэрхэн цэвэрлэх вэ гэдэгт бэлээхэн хариулт (манайд туршлага болно) олжээ. Гол нь аж үйлдвэрийн бүтэц, эрчим хүчний бүтэц, зам харилцааны бүтэцдээ ухаалаг өөрчлөлт хийнэ гэнэ. Юуны өмнө нүүрсэнд хэт түшиглэсэн эрчим хүчний бүтцийг өөрчлөх ба гол бүс нутгуудын нүүрсний хэрэглээний ерөнхий хэмжээг бууруулна. Зам харилцаандаа хүнд даацын авто машины тээвэрлэлтийг багасгана. Хурдны төмөр замаар тээвэрлэхийг өсгөнө, хүнд даацын авто машины утаа ялгаруулахыг хатуу хянах, хориглох руу шилжинэ. Ийм ажлуудыг тусгасан 2020 он хүртлэх агаарын бохирдлыг арилгах гурван жилийн хөтөлбөр зарлажээ.

### Долоо. Онолын зохиогч тодорчээ

Дээрх лут зорилтуудыг нийлүүлж базаад, түүндээ хүрэх арга замыг оролцуулаад “Шинэ эрин үеийн Хятадын онцлогтой социализм байгуулах Ши Жиньпиний үзэл санаа” хэмээх шинэ үзэл баримтлал гаргаж ирэн, ХКН-ын Дүрэмдээ суулгаж, 2018 онд чуулсан Ардын Төлөөлөгчдийн Их хурлаараа хэлэлцэн дэмжиж, шинэ эриндээ БНХАУ-ын дарга тодорхой хугацаанд баригдахгүйгээр (“5 жил+5 жил” гэснийг цуцалсан) ажиллахаар Үндсэн хуульдаа өөрчлөлт оруулжээ.

Шинэ эрин үедээ Хятад нь 9 салбарт хүч анхаарлаа төвлөрүүлж ажиллана. Үүнд 1) эдийн засаг, 2) улс төр, 3) соёл, 4) иргэдийн амьжиргаа, 5) нийгмийн засаглал, 6) экологи, 7) батлан хамгаалах, армийн бүтээн байгуулалт, 8) эх орны нэгдэл, гадаад харилцаа, 9) намын байгуулалт байх ажээ.

Энэчлэн төддүгээрт, төддүгээрт гэсэн заалт намын 2017 оны их хурал, 2018 оны чуулганаас олныг зааж өгчээ. Зах зухаас нь дурдвал: Хувиралтгүй хоёр, хөгжлийн хоёр үе шат, гурван баримтлал, дөрвөн аугаа их, намын дөрвөн хүчин зүйл, чинээлэг нийгэм байгуулах 7 стратеги, шинэ эрин үеийн Хятадын онцлогтой социализмын үзэл бодлын 8 тодорхойлолт, төр-засаг барих 8 ур чадвар, шинэ эрин үеийн Хятадын онцлогтой социализм байгуулахад баримтлах 14 зарчим гэх мэт.

Заримаас нь дурдвал тэрхүү “Дөрвөн аугаа их” гэдэг нь – аугаа их (1) тэмцэл, (2) төсөл, (3) ажил үйлс, (4) мөрөөдөл болох аж. Задалбал өнөөдөр “Хятад мөрөөдөл”-ийг биелүүлэхэд хамгийн ойр зааг үед тулж ирсэн, түүндээ ч итгэлтэй байна. Аугаа их тэр мөрөөдлийг биелүүлэхэд аугаа тэмцэл, их төслийн лут бүтээн байгуулалт хийж, тэгснээрээ аугаа их үйлсийг бүтээнэ хэмээн тайлбарлажээ.

Тэр 7 стратеги гэдэг нь хэрэгжүүлэх бодит арга замыг заасан зорилтууд байх аж. Үүнд 1) Шинжлэх ухаанд түшиглэн улс орноо мандуулах; 2) Хүний нөөц, хүний хүчин зүйлээр улсаа хүчирхэг болгох; 3) Инновацыг хөдөлгөх хүчний хөгжлийн стратеги гэж үзэх; 4) Хөдөө орон нутгийг тусад нь авч үзэн хөгжүүлэх; 5) Бүс нутгийн хөгжлийн тэнцвэрийг барих; 6) Хөгжлийг огт сааруулахгүй хөгжүүлсээр байх; 7) Цэрэг, ард түмэн уялдан нэгэн зэрэг хөгжих гэж томъёолжээ.

Тэр 14 зарчим гэдэг нь урт хугацаанд баримтлах, мөрдөх, хэрэгжүүлэх бичигдээгүй хууль юм болов уу гэж үзэхээр юм. Үүнд:

1. Коммунист намаас бүх ажил үйлсийг удирдах
2. Ард түмнээ төвдөө тавих
3. Өөрчлөлт шинэчлэлийг бүх талаар гүнзгийрүүлэх
4. Хөгжлийн шинэ үзэл бодол дэвшүүлэх
5. Ард түмэн эзэн, ард түмэн эрх эдлэх зарчим баримтлах
6. Хуулийн дагуу засаглах
7. Социализмын байгууллын үндсэн өртгийн үзлийг баримтлах
8. Хөгжлийн дагуу ард түмний амьжиргааг сайжруулах, тийм баталгаагаар хангах
9. Хүн төрөлхтөн, эх дэлхийн эв найрамдалтай хөгжлийг хангах
10. Улс орны аюулгүй байдлыг сахин хамгаалах
11. Коммунист намаас цэрэг армийг удирдах
12. “Нэг улс-нийгмийн хоёр байгуулал”-Хятадын нэгдлийн үзэл баримтлалыг баримтлах
13. Хүн төрөлхтний нийтлэг хамтын хувь тавиланг цогцлуулах
14. Коммунист намыг бүх талаар чанд засан цэгцлэх гэж заажээ.

### **Найм. Дүгнэлтийг орлуулж Монгол руугаа татаж сэтгэе**

Энэ их зорилт заалтуудаа азнаж, Монголд маань хэрэгтэй байж мэдэх биет мэдээллээс толилуулъя. Өмнөх бидний төсөөлдөг шиг Хятад нь бэлэн бараагаар дэлхийг дарж, экспортод л гаргаж байвал юу ч хамаагүй гэдгээ больж байгаа нь маргаангүй илт болсон зүйл. Хятадын Чанар, хорио цээрийн үндэсний ерөнхий газрын дарга Жи Шүпин гэдэг нөхрийн ярьснаар бол Хятадын барааны чанар чансаа тасралтгүй дээшилж, олон улсын (дэлхийн) стандартын шалгуурт нийт барааны 85.47 хувь нь тэнцсэн гэжээ. 2013-2018 оны 5 жилд барааны чанар дээшлүүлэх өргөн хүрээтэй үйл ажиллагаа явуулсаар Хятад нь чансаатай хөгжлийн цаг үеийн шаардлагад хөл нийлүүлэх болжээ. Өөрөөр хэлбэл бид

энүүхэн хаяанаас, Эрээнээс брэнд бараагаа дэлхийн дундаж үнээр худалдан авах цаг айсуй.

Хятадын Худалдааны яамны дэд сайд бөгөөд олон улсын худалдааны хэлэлцээний орлогч төлөөлөгч Ван Шөүвэний ярьснаар, Хятад нь дэлхийн 24 улс орон, бүс нутагтай чөлөөт худалдааны 16 хэлэлцээрт гарын үсэг зурсан, олон талт худалдааны хэлэлцээг дэмжсээр байх болно, чөлөөт худалдааны түнш бус улс орнуудтай тогтоосноос илүү хурдтайгаар чөлөөт худалдааны түншүүдийн худалдаа, хөрөнгө оруулалтын харилцаа хөгжиж байна гэсэн нь анхаарал татлаа.

Хятадын өнөөгийн эдийн засаг гадаад зах зээлээс ихээхэн хамаардаг гэдэг нь мэдээж. Экспортоороо дэлхийд нэгдүгээр цохиж явдаг улс. Тус улсын валютын орлогын 80 хувийг экспорт нь бүрдүүлдэг. Тэр 80 хувь дотор манайхны жин оролцоо ч чамгүй бий. Гэтэл улс нь валютын орлогынхоо 80 хувийг бүрдүүлдэг салбар ердөө 20 сая хүн ажиллаж байгаа нь тайлагдашгүй оньсого юм. Бас аж үйлдвэр, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийхээ 20 хувийг гадаад зах зээлд гаргадаг гэхлээр бас нэг толгой эргэм оньсого. Экспортын бараа бүтээгдэхүүн гэвэл 50 мянган нэр төрөл. Цаашлаад бүр гайхам тоонууд ярайж байна. Дэлхийн 182 улс оронтой худалдааны харилцаатай, тэдгээрээс 80-тай нь Засгийн газар хоорондын хэлэлцээр, протоколтой. Энэ 182-оосоо бараг 120-д нь худалдааных нь гол түнш Хятад гэгдэж яваа. Худалдааны гол түнш нь хөгжингүй капиталист бүх орон. Юуны өмнө Япон, АНУ, Өрнөд Европын орнууд, тэдэнд хятадын гадаад худалдааны эргэлтийн 55 хувь ногдоно.

Энэ бүхнийг манай худалдаа, эдийн засгийн эрх баригчид, хувийн худалдаачид анхааралдаа авах биз ээ. Учир нь манай улс бол Хятадтай хуурай газраар маш том хилтэй, хил орчмоороо олон боомттой, иргэд ердийн ба ганзагын худалдаа эрхэлдэг, Монголын бүх хотууд хятадын бараанд дарагдсан гэж үзвэл Хятадын гадаад худалдааны талаар маш цэгц ойлголт мэдлэг, мэдрэмжтэй байх хэрэгтэй билээ.